

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашням	Дугаар	L010
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Улаанбаатар хот	Төрсөн он	1913
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Идгаа дацан	Сүм хийдийн дугаар	UBR 912
Одоогийн сүм хийд	Ламрим хийд	Сүм хийдийн дугаар	UB 04
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 14	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Идгаа дацан

1994 оноос Ламрим дацанд судлаж хурж эхэлсэн. Нийгмийг аюулаас хамгаалах яаманд харуул, манаач зэрэг ажил хийж байсан.

Манайх 100 гаран ламтай байсан. Би Идгаад хурлын уншлага ном судлаж байсан. Миний багш гэгээний цорж Равдан гэдэг хүн байсан. Нэлээн том хүн байсан. Манай зиндаанд 25 хүүхэдтэй байсан. 25-уул дом тавиад тэгээд хурал ном хаагдсан. Би ойр зуурын хурлын уншлага л уншиж цээжилж байснаас өөр гүн ухаан зэрэг тусгай зүйл байгаагүй. Дүйнхорын аймаг миний хурал хоёр өөр болчоод байна. Дээр үед намайг сууж байхад хурал номын дэг жаяг, лам нарын дэг журам их сайн байсан. Одоотой харьцуулах юм байхгүй. Одоо сүм хийд хурал номын ажиллагаагаа дэгтэй сайн явуулах хэрэгтэй гэж бодож байна. Ер нь жаахан замбараагүй болж байгаа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Идгаа дацангийн сахиус Дамдинчойжоо сахиус. Тэр үед хамба лам нь Гомбожав. Гайнаа гэдэг хүн гэсгүй нь байсан. Чомбо нь би. Гэндэн лам гэдэг хүн үнзад нь байсан. Дарамбазар гэдэг хүн чомбо байсан.

Майдар 7 сарын 13-нд гардаг байсан. Майдраа 4 үетэй эргэж байсан. Хамгийн эхлээд урд тал тэгээд баруун тал, хойд тал, зүүн тал гээд эргэнэ.

Жилд 1 удаа Майдар, цам гарна. Хамгийн сүүлийн цам 1925 онд (1935) гарсан. Нэг өдрийн хугацаанд эргэнэ. Би Гомбо сахиусанд харайж байсан. Цамд гарахын тулд 7-8 хоног нямба даяан хийнэ. Цамд 10 хангал 10-уул гардаг байсан.

Дагва гэдэг алдартай эмч байсан. Хутагт хувилгаад байгаагүй. Хүрээ 7 цоржтой байсан. Манай дацанд 60 гаруй гэлэн сахилтай хүн байсан. Хайлан хурна. Хайланг 45 хоног хурна. Нүгнээ сахина.

1920-иод оны үед лам хуврагийн амьдрал сайн сайхан байсан. Юм бүхэн элбэг дэлбэг. Сүсэгтэн, лам нарын харилцаа эв найрамдалтай, дэг журамтай байсан. Миндагтай лам нарыг нь бариад мань мэтийн амьтад нь үлдсэн. Одоо манай зиндаанаас надаас гадна нэг хүн байгаа. Хайлаастанд байгаа Дашцэрэн гэдэг хүн бий. Надад дацангийн нэлээд түүх, баримт байсан юм. Манай хоёр гэр шатаад түүнтэй цуг алга болсон.